

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Экспортыг дэмжих төслийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2023/73/НА-СТА-ТХН

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2023 он</p>	<p>Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг Утас: 261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: П.Чанцалдулам Утас: 261885 Цахим хаяг: chantsaldulamp@audit.gov.mn Ахлах аудитор: И.Эрдэнэцэцэг Утас: 261628 Цахим хаяг: erdenetsetsegi@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Грант Торнтон аудит ХХК Захирал: Б.Осоргарав Утас: 70110744 Цахим хаяг: osorgarav.b@mn.gt.com</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2023.02.24 № 07/364
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Экспортыг дэмжих төслийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Экспортыг дэмжих төслийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Гадаад худалдаа, экспортын чадвах бэхжүүлэх, уул уурхайн бус аж ахуй нэгжүүдэд гадаад экспортын чадвахыг нэмэгдүүлэх сургалтыг 20 удаа зохион байгуулж, Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн суурь судалгаа, адал явдалт аялал жуулчлалын, 10 шилдэг эвент гэх мэт томоохон судалгааны ажил хийсэн байна.

Аудитын гол асуудал

Бидний мэргэжлийн үнэлэмжээр аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн тусдаа дүгнэлт гаргаагүй болно.

Монгол Улс, Олон Улсын Хөгжлийн Ассоциаци хоорондын 2016 оны 8 дугаар сарын 26-ны өдрийн 5879 MN дугаартай 20,000,000 ам.долларын санхүүжилтийн хэлэлцээрийн дагуу Төсөл хэрэгжүүлэх нэгжийн хугацааг 2021 оны 6 дугаар сарын 30-наар дуусахаар байсан хэдий ч 2020-2021 онуудад үүссэн Ковидын нөхцөл байдал, Төслийн үндсэн зорилгын гүйцэтгэл зэргээс хамааран 2023 оны 12 дугаар сарын 31-нийг хүртэл сунгасан байна. Тухайлбал:

- Түншлэлийн гэрээний хүрээнд 2021-2022 онуудад 68 аж ахуй нэгжид буцалтгүй дэмжлэг олгохоор 4,049,281.1 мянган төгрөгийн гэрээ байгуулсан. Үүнээс 1,922,095.0 мянган төгрөгийн гэрээтэй 35 аж ахуй нэгж шалгуур үзүүлэлтийн дагуу баримт материалаа ирүүлэн гүйцэтгэлээр дэмжлэгээ авч гэрээнд заасан үүргээ хэрэгжүүлсэн, 7 аж ахуй нэгжийн 397,807.9 мянган төгрөгийн гэрээ хэрэгжээгүй, 13 аж ахуй нэгжийн 894,446.0 мянган төгрөгийн гэрээ 2023 онд хэрэгжүүлэхээр сунгагдсан, 13 аж ахуй нэгжийн 774,899.5 мянган төгрөгийн гэрээ дэмжлэг хүртэгчдийн зүгээс шалгуурт нийцсэн баримт материал ирүүлээгүйгээс хүлээгдэж байна. Цар тахал давагдашгүй нөхцөл байдлын улмаас 2022 оны төслийн үр шим хүртэгчдийн экспортын өсөлтийн суурь шалгуур 19%-д хүрээгүй байна.
- Тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 22,963,878.6 мянган төгрөгийн 33 худалдан авалт хийхээр төлөвлөсөн боловч 15 худалдан авалтыг тогтоосон хугацаандаа хийгээгүй 45 хувийн гүйцэтгэлтэй байна.
- Төсөл хэрэгжүүлэх нэгж нь 2022 онд төслийн үндсэн зорилгын хүрээнд хэрэгжих 4 бүрэлдэхүүн хэсэгт 89 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 69 хувийн хэрэгжилттэй ажилласан байна.

Төсөл хугацаандаа дуусахгүй сунжрах нь төсөл хэрэгжүүлэх нэгжийн зардал нэмэгдэх, Дэлхийн банкны санхүүжилт буцаан татагдах, төслийн үр ашиг буурах эрсдэлтэй гэж үзсэн тул аудитын гол асуудалд оруулж, Төслийн удирдах хорооны анхаарлыг хандуулах нь зүйтэй гэж үзэв.

Бусад асуудлын хэсэг

Экспортыг дэмжих төсөл нь Дэлхийн банкнаас баталж гаргасан “Санхүүгийн удирдах гарын авлага”-ын дагуу нягтлан бодох бүртгэлийн мөнгөн суурийн дагуу бэлтгэсэн санхүүгийн тайланг Дэлхийн банкинд хүргүүлдэг бол Төсвийн гүйцэтгэлийн тайланг Сангийн сайдын 2007 оны 326 дугаар тушаалаар баталсан “Засгийн Газрын шугамаар авч, ашиглаж буй хөнгөлөлттэй зээл болон буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр, Засгийн Газрын тусгай санд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан, тодруулгын маягтууд, санхүүгийн тайланг бэлтгэж гаргах аргачлал”, УСНББОС 1-ийн дагуу аккруэл сууриар илэрхийлэн бэлтгэн хүргүүлдэг байна.

Төслийн зорилгыг хэрэгжүүлэх үүднээс төслийг бие даасан зорилт бүхий дөрвөн үндсэн бүрэлдэхүүн хэсэг болгон зохион байгуулж Үндэсний давхар даатгал хувьцаат компани болон Төсөл хэрэгжүүлэх нэгж хэрэгжүүлнэ. Төслийн хэрэгжилтэд хяналт тавих, удирдлагаар хангах гол байгууллага нь Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ- НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	2,396,299,996.45	2,980,634,257.69
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	2,396,299,996.45	2,980,634,257.69
31100	Кассанд байгаа бэлэн мөнгө	2,393,773.20	-
31110	Төгрөг	2,393,773.20	-
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	2,393,906,223.25	2,980,634,257.69
31210	Төгрөг	1,244,847,785.63	838,322,536.94
31211	Төрийн сангийн харилцах	1,244,847,785.63	838,322,536.94
31220	Гадаад валют	1,149,058,437.62	2,142,311,720.75
31221	Төрийн сангийн харилцах	1,149,058,437.62	2,142,311,720.75
31223	Арилжааны банк дахь харилцах	-	-
33	АВЛАГА	-	-
33500	Бусад авлага	-	-
33520	Хувь хүмүүсээс авах авлага	-	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	70,924,730.38	49,436,289.71
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	70,924,730.38	49,436,289.71
39200	Биет хөрөнгө	66,847,930.38	46,436,298.71
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	92,997,825.00	92,997,825.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(52,017,903.55)	(69,434,345.22)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	33,759,141.75	33,759,141.75
39208	Хуримтлагдсан элэгдэл	(7,891,132.82)	(11,198,722.82)
39214	Бусад үндсэн хөрөнгө	-	-
39215	Хуримтлагдсан элэгдэл	-	-
39300	Биет бус хөрөнгө	4,076,800.00	3,312,400.00
39301	Програм хангамж	7,644,000.00	7,644,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(3,567,200.00)	(4,331,600.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,467,224,726.83	3,030,070,556.40
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
41300	Өглөг	-	-
41360	Бусад өглөг	-	-
41361	Байгууллагад төлөх өглөг	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,467,224,726.83	3,030,070,556.40
51	Засгийн газрын хувь оролцоо	2,467,224,726.83	3,030,070,556.40
51200	Хуримтлагдсан үр дүн	2,467,224,726.83	3,030,070,556.40
51210	Өмнөх үеийн үр дүн	3,131,691,248.70	2,467,224,726.83
51220	Тайлант үеийн үр дүн	(664,466,521.87)	562,845,829.57
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,467,224,726.83	3,030,070,556.40

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,372,842,164.63	7,395,408,830.34
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,372,842,164.63	7,395,408,830.34
120	Нийтлэг татварын бус орлого	1,372,842,164.63	7,395,408,830.34
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,372,842,164.63	7,395,408,830.34
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос анхүүжих	-	-
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	1,372,842,164.63	7,395,408,830.34
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,013,557,164.57	7,087,958,423.33
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,013,557,164.57	7,087,958,423.33
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,013,557,164.57	7,087,958,423.33
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	231,924,909.26	193,209,972.24
210101	Үндсэн цалин	231,924,909.26	193,209,972.24
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд өлөх шимтгэл	29,917,712.61	24,151,246.56
210201	Тэтгэврийн даатгал	29,917,712.61	17,754,538.52
210202	Тэтгэмжийн даатгал	-	2,329,642.86
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	1,879,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	-	2,188,065.18
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	75,810,640.00	49,095,000.00
210304	Байрны түрээс	75,810,640.00	49,095,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	14,086,070.77	13,993,664.60
210401	Бичиг хэрэг	2,624,135.90	2,741,768.27
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11,461,934.87	11,251,896.33
2107	Томилолт, зочны зардал	1,000,000.00	824,600.00
210702	Дотоод албан томилолт	1,000,000.00	824,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,643,867,468.59	6,785,195,508.26
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,643,867,468.59	6,785,195,508.26
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,950,363.34	21,488,431.67
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	16,950,363.34	21,488,431.67
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(640,714,999.94)	307,450,407.01
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	255,395,422.56
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	-	255,395,422.56
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	23,751,521.93	-
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	22,379,613.87	-
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	1,371,908.06	-
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(664,466,521.87)	562,845,829.57

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээн ий нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	3,131,691,248.70	3,131,691,248.70
Тайлант үеийн үр дүн	-	-	(664,466,521.87)	(664,466,521.87)
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	2,467,224,726.83	2,467,224,726.83
Тайлант үеийн үр дүн	-	-	562,845,829.57	562,845,829.57
2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	-	-	3,030,070,556.40	3,030,070,556.40

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,372,842,164.63	7,395,408,830.34
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,372,842,164.63	7,395,408,830.34
120	Нийтлэг татварын бус орлого	1,372,842,164.63	7,395,408,830.34
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,372,842,164.63	7,395,408,830.34
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	-
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	1,372,842,164.63	7,395,408,830.34
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,995,095,050.93	7,066,469,991.66
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,995,095,050.93	7,066,469,991.66
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,995,095,050.93	7,066,469,991.66
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	231,924,909.26	193,209,972.24
210101	Үндсэн цалин	231,924,909.26	193,209,972.24
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,917,712.61	24,151,246.56
210201	Тэтгэврийн даатгал	20,999,912.61	17,754,538.52
210202	Тэтгэмжийн даатгал	2,282,000.00	2,329,642.86
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,831,600.00	1,879,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	420,400.00	-
210205	Эрүүл мэндийн даатгал	4,383,800.00	2,188,065.18
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	75,810,640.00	49,095,000.00
210304	Байрны түрээс	75,810,640.00	49,095,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	14,086,070.77	13,993,664.60
210401	Бичиг хэрэг	2,624,135.90	2,741,768.27
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11,461,934.87	11,251,896.33
2107	Томилолт, зочны зардал	1,000,000.00	824,600.00
210702	Дотоод албан томилолт	1,000,000.00	824,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,642,355,718.29	6,785,195,508.26
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,642,355,718.29	6,785,195,508.26
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	(622,252,886.30)	328,938,838.68
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	30,387,300.00	0.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	30,387,300.00	0.0
2200	Дотоод эх үүсвэрээр	30,387,300.00	0.0
222001	Тоног төхөөрөмж	30,387,300.00	0.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(30,387,300.00)	0.0
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(1,371,908.07)	255,395,422.56
14	Бусад эх үүсвэр	0.0	255,395,422.56
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	0.0	255,395,422.56
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	1,371,908.07	0.0
250001	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	1,371,908.07	0.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(654,012,094.37)	584,334,261.24
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3,050,312,090.82	2,396,299,996.45
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,396,299,996.45	2,980,634,257.69

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	7,126,734,300.00	7,066,469,991.66	60,264,308.34	99.2
УРСГАЛ ЗАРДАЛ	7,126,734,300.00	7,066,469,991.66	60,264,308.34	99.2
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,126,734,300.00	7,066,469,991.66	60,264,308.34	99.2
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	195,000,000.00	193,209,972.24	1,790,027.76	99.1
Үндсэн цалин	195,000,000.00	193,209,972.24	1,790,027.76	99.1
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,384,300.00	24,151,246.56	3,233,053.44	88.2
Тэтгэврийн даатгал	18,901,200.00	17,754,538.52	1,146,661.48	93.9
Тэтгэмжийн даатгал	2,349,000.00	2,329,642.86	19,357.14	99.2
ҮОМШӨ-ний даатгал	1,879,000.00	1,879,000.00	-	100.0
Ажилгүйдлийн даатгал	470,000.00	-	470,000.00	-
Эрүүл мэндийн даатгал	3,785,100.00	2,188,065.18	1,597,034.82	57.8
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	49,620,000.00	49,095,000.00	525,000.00	98.9
Байрны түрээс	49,620,000.00	49,095,000.00	525,000.00	98.9
Хангамж, бараа материалын зардал	14,630,000.00	13,993,664.60	636,335.40	95.7
Бичиг хэрэг	2,784,000.00	2,741,768.27	42,231.73	98.5
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11,846,000.00	11,251,896.33	594,103.67	95.0
Томилолт, зочны зардал	1,000,000.00	824,600.00	175,400.00	82.5
Дотоод албан томилолт	1,000,000.00	824,600.00	175,400.00	82.5
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,839,100,000.00	6,785,195,508.26	53,904,491.74	99.2
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,839,100,000.00	6,785,195,508.26	53,904,491.74	99.2
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	7,126,734,300.00	7,395,408,830.34	(268,674,530.34)	103.8
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	7,126,734,300.00	7,395,408,830.34	(268,674,530.34)	103.8
Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	7,126,734,300.00	7,395,408,830.34	(268,674,530.34)	103.8
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	2,396,299,996.45	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	2,980,634,257.69	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тохируулгын өөрчлөлт	-	255,395,422.50	(255,395,422.50)	-

Гурав. Аудитын илрүүлэлт:

Санхүүгийн тайлангийн аудитаар эдийн засгийн ангилал зөрчиж гүйлгээ хийсэн 1,000.0 мянган төгрөгийн 1 алдааг аудитын явцад залруулж, арилгасан.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Байрны засвар үйлчилгээний зардал 1,000.0 мянган төгрөгийг байр түрээсийн зардлын ангиллаас гаргасныг аудитын явцад залруулсан.	1	1,000.0					1	1,000.0				
Дүн	1	1,000.0					1	1,000.0				

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 2,942.8 мянган төгрөгийн 4 зөрчил¹ илэрснээс, 1,865.4 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 1,077.4 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг дахин давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд бүртгэлтэй Ландкрузер-200 автомашины урсгал, засвар	1	1,865.4			1	1,865.4						

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

үйлчилгээнд зориулан 1,865.4 мянган төгрөгийг зарцуулсан.											
Түншлэлийн гэрээний хүрээнд буцалтгүй дэмжлэг байдлаар олгох нөхцөлтэй 2022 онд дуусах 68 ААН-тэй 4,049,281.1 мянган төгрөгийн гэрээ байгуулснаас 7 ААН-ийн 397,807.9 мянган төгрөгийн гэрээ хэрэгжээгүй, 13 ААН-ийн 774,899.5 мянган төгрөгийн ажлууд дэмжлэг хүртэгчийн зүгээс санхүүжилтийн шалгуурт нийцсэн баримт материалыг төсөл хэрэгжүүлэх нэгжид хүргүүлээгүйгээс санхүүжилт олгогдоогүй хүлээгдэж байна.	1	-			1						
Төслийн удирдах хорооны тогтоолоор баталсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 33 ажлаас 18 нь хугацаандаа , 11 сард шинээр нэмэгдсэн 2 ажил нь ажлын даалгавар боловсруулах шатанд, 13 ажил нь 2023 оны төлөвлөгөөнд тусгагдан үргэлжлэхээр болсон нь төсөл хэрэгжих хугацаанд хэрэгжилт нь бүрэн дуусахгүй байх эрсдэлтэй байна.	1	-			1						
Үнэлгээний хорооны 7 гишүүнд 1,077.4 мянган төгрөгийн урамшууллыг түншлэгч байгууллагуудын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээр олгосон байна.	1	1,077.4					1	1,077.4			
Дүн	4	2,942.8			3	1,865.4	1	1,077.4			